

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 12 өдөр

Дугаар Р/20

Бөхт

Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах
тухай

Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 4.1.4, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн 2 дугаар багийн эмч Болдын Болормаатай байгуулсан орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах гэрээний хэрэгжилтийг зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар хангалттай гэж дүгнэн гэрээний дагуу нутгийн тэтгэлэг 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 5,000,000 (таван сая) төгрөгийн тэтгэлэг олгосугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн санхүүжилтээс гаргаж, холбогдох баримтыг бүрдүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал), нярав (Т.Батбилэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

4823010043